



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах
салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх заалт, 42 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлж үр дүнг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Л.Баярмаа)-т үүрэг болгосугай.

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох эрхийг хангах, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны А/46 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010347

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 02 өдрийн 44 дугаар
захирамжийн хавсралт



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар
зөвлөлийн бүрэлдэхүүн

Тэргүүн:	Дүүргийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
	Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга
	Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга
	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Дүүргийн Цагдаагийн газрын дарга
	Дүүргийн Биеийн тамир, спорт хорооны хорооны дарга
	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга
	Дүүргийн Соёлын төвийн дарга
	Дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга
	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)

Дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)

Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний
холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)